



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 01 оны 18 сарын 25

№ 368

Улаанбаатар хот

Хотын киноны байгууллагуудын
зохион байгуулалтын тухай.

Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас
ТОГТООХ НЬ:

1. БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Хотын кино зураг техникийн үйлчлэгээний төвийн оноосон нэрийг " Улаанбаатар кино" компани, Ард кино театрын оноосон нэрийг " Ард Кино " компани /УҮГ/ болгон байгуулсугай.

2. " Улаанбаатар кино " компани, " Ард кино " компани, Ялалт кино театр, " Өргөө " кино театр, "Од кино театр, Хөдөлмөр кино театр, Налайх кино театруудыг Төрийн өмчтэй улсын үйлдвэрийн газар болгон байгуулж киноны үйлчлэгээг хэвээр явуулж дүрмийг баталсугай.

3. Нийслэлийн киноны байгууллагуудыг цаашид хувьчлах тухай асуудлыг 1992 онд шийдвэрлэхийг Хотын өмч хувьчлалын комиссын дарга н.Ганхуягт үүрэг болгосугай.

4. " Улаанбаатар кино " компани, " Ард кино " компани, Өргөө, Ялалт, Сансар, Хөдөлмөр, Од, Элдэв-Очир Налайх кино театруудыг / УҮГ/ болгон бие даасан тайлан тэнцэл бүхий аж ахуйн нэгж байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэн ажиллахыг дэд дарга Т.Сарантуяад даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА *[Signature]* Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* Ц.БОЛДСАЙХАН

Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны 1991 оны
368-тогтоолын хавсралт

" УЛААНБААТАР КИНО " КОМПАНИ /УУГ/-ЫН
ЦГЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. "Улаанбаатар кино" компани /УУГ/-нь нийслэл хот, дагуул хотууд, САА, хороодын хөдөлмөрчид, зусланд кино үзвэрээр үйлчлэх ажлыг хариуцан Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүлэгчид, Гүйцэтгэх захиргаанаас гаргасан эрх зүйн баримт бичгүүд, энэ дүрмийг үндэслэн кино үйлчилгээг явуулна.

2. "Улаанбаатар кино" компани нь дүрэм зааврын дагуу хийгдсэн тамга, тэмдэг, бичгийн нүүртэй, банкнд тусгай данстай захирлын тушаал гаргах эрхтэй ажиллана.

3. "Улаанбаатар кино" компанийн захирлыг Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаан төсвийн бичгүүдээр гэрээний үндсэн дээр ажиллана.

4. "Улаанбаатар кино" компанийн үйл ажиллагааг захирал удирдаж Хотын Ардын хурал гүйцэтгэх захиргааны өмнө ажил хариуцаж тайлангаа тавина.

5. "Улаанбаатар кино" компани нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлтэй байна.

6. "Улаанбаатар кино" компани нь хотын санхүү татварын анбаад бүртгэгдэж санхүүгийн гайдын гэнцлээ эгч тэрлээ хийж ажиллана.

КОӨР. "Улаанбаатар кино" компанийн
үүрэг

1. "Улаанбаатар кино" компани /УУГ/-нь нийслэлийн кино театр, суурин нүүдлийн кино бэг, гэрээт газруудад "Монголфильм" үзвэрийн газар болон гадаадаас кино зураг, киноны тонг төхөөрөмж, сэдбэгийг гэрээний дагуу ханган нийлүүлэх зэргээр гүйцэтгэнэ.

2. "Улаанбаатар кино" компани нь аж ахуйн бүрэн тосгоон дээр ажиллана.

3. "Улаанбаатар кино" компани нь нийслэлийн хөдөлмөрчдийн кино үйлчилгээг өргөтгөх шинэ дэвшилтэй үйлчилгээ техник, технологи нэвтрүүлэх үүргийг хүлээнэ.

4. "Улаанбаатар кино" компани нь аж ахуйн тооцоон дээр ажиллаж компанийн хамт олон, хүмүүсийг шагнаж урамшуулах, гачигдал тохиолдсон үед тусламж тэтгэмжийг цэвэр ашгаас байгуулсан Хөрөнгөөс 50% хүртэл хувиар зарцуулна.

ГУРАВ. "Улаанбаатар кино" компанийн эрх

1. Нийслэл хотын киноны үйлчилгээг хэвийн байлгах зорилгоор кино үзвэрээр хөдөлмөрчдөд үйлчилдэг киног театр кино цэгийн ажиллагаанд зөвлөлтөө өгч туслахыг үзүүлэх ба хяналт шалгалт тавина.

2. Нийслэлийн хөдөлмөрчдөд киноны үйлчилгээний хүрээг өрөгжүүлэхэд анх өрч шинээр кино цэг салбар нээж ажилдуулна.

3. БНМАУ-ын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал, заавар гарган өөрийнхөө байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх ба хууль тогтоомж эрх зүйн бичиг баримтын хэрэгжилтэнд хяналт тавина.

4. "Улаанбаатар кино" компанид ажиллагсадтай холбогдсон нийгмийн асуудал, гэрээ, шагнал, арга хэмжээг тушаал гарган шийдвэрлэнэ.

5. Киноны үйлчилгээг өргөжүүлэх чанаржуулах зорилгоор урагдаан зарлаж хамт олныг идэвхжүүлэх талаар шинэлэг арга хэлбэрийг ашиглана.

ДӨРӨВ. Хөрөнгө санхүү

1. "Улаанбаатар кино" компани /УУГ/ нь үндсэн ба эргэлтийн Хөрөнгөтэй хөрөнгө материалыг эрх хэмжээний дагуу зарцуулна.

2. Санхүү гатварын албадад тайлан гэнцэл, мэдээ бүртгэлээ үнэн зөв гаргаж, кино механикчидтай санхүүгийн тооцоог хийж байх,

3. Аж ахуйн тооцоон дээр ажиллаж олсон цэвэр ашгийг сар дутам тооцож хуваарилна.

4. " Кино зургийг кино театруудад прокатаж, түүнээс олсон орлогоор кино худалдан авна.

ТАВ. "УЛААНБААТАР КИНО" компанийг
еөрчлөн татан буулгах

"Улаанбаатар кино" компанийг татан буулгах еөрчлөх асуудлыг зөвхөн Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ.